

БАТЛАВ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

Ч.УРАНЧИМЭГ

.....

БАТЛАВ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ОНЦГОЙ БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ

Ж.ГАНБАТ

.....



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМАНД ХЭРЭГЖИХ “НҮҮРС БАЯЖУУЛАХ
ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5435528

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

Ц.ЖАРГАЛНЭМЭХ

БОЛОВСРУУЛСАН:

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
БОУБХ-ИЙН ДАРГА

О.ГҮРРАГЧАА

Гарчиг

1	ОРШИЛ	1
2	Төслийн ТОВЧ танилцуулга.....	1
2.1	Төслийн зорилго, хүчин чадал.....	1
	Төслийн ерөнхий төлөвлөлт	1
	Ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч байгууллагуудын мэдээлэл	2
3	ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	3
3.1	Уур амьсгал	3
3.2	Геоморфологи	3
3.3	Хөрс.....	3
3.4	Ургамлан бүрхэвч.....	3
3.5	Нийгэм, эдийн засаг	4
3.6	Төслийн талбайн байршил	4
4.	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	6
4.1	Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц.....	6
5	СӨРӨГ НӨЛӨӨЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ.....	7
	Газрын гадарга, хэвлий.....	7
	Агаарын чанар	7
	Уур амьсгал	8
	Гадаргын болон газрын доорх ус.....	8
	Ургамлан нөмрөг	8
	Амьтны аймаг	8
	Тусгай хамгаалалттай газар нутаг	8
	Дуу шуугиан	8
	Нийгэм, эдийн засаг	8
	Түүх, соёлын дурсгалт зүйлс	8
	Хог хаягдлын менежмент	8
6.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	10
7.	ОРЧНЫ ТОХИЖИЛТ, Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	12
8.	дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
9.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	13
10.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	14
11.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	15
12.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	16
13.	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	17
	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв.....	18
	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР	18

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт № 1. Нүүрс баяжуулах үйлдвэрийн ажиллах горим, хүчин чадал	1
Хүснэгт № 2. Туслан гүйцэтгэгч компаниудын мэдээлэл	2
Хүснэгт № 3. "Нүүрс баяжуулах үйлдвэр" төслийн талбайн хэмжээ	5
Хүснэгт № 4. Эрсдэлийн үнэлгээний матриц	6
Хүснэгт № 5. Магадлалын үнэлгээний шалгуур	6
Хүснэгт № 6. Үр дагаварын үнэлгээний шалгуур	6
Хүснэгт № 7. Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт.....	7
Хүснэгт № 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	10
Хүснэгт № 9. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө	12
Хүснэгт № 10. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	12
Хүснэгт № 11. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	13
Хүснэгт № 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	14
Хүснэгт № 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	15
Хүснэгт № 14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ба зардал	16
Хүснэгт № 15. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	17
Хүснэгт № 16. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв	18

1 ОРШИЛ

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, Улсын Их Хурлын 2010 оны “Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” 39 дүгээр тогтоол, 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газраас 2019 онд баталсан “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр”, мөн Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2019 онд баталсан “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 41 тоот тогтоолоор батлагдсан 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/455 тоот тушаалаар байгуулагдсан “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тулгуурлан Тавантолгойн ордыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах нь шинэ, дэвшилтэт болон өндөр технологи, дамжуулах, нутагшуулах болон нэмүү өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлээд зогсохгүй уул уурхай, зам тээвэр, усан хангамж, байгаль орчин зэрэг олон салбарыг хамарсан цогц бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг “Нүүрс баяжуулах үйлдвэр” –ийн батлагдсан ТЭЗҮ-ийн хүрээнд БОАЖЯ-ны 2022 оны 02-р сарын 28 өдрийн 13/1034 дугаар бүхий ерөнхий үнэлгээний дүгнэлтэд үндэслэн БОНХЯ-ны (хуучин нэрээр) 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу боловсруулав.

БОННУ-ний ажлын үр дүнд үйлдвэрийн барилга байгууламж барих үеийн болон үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагааны үе дэх байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоон үнэлсэн бөгөөд сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, улмаар хамгийн бага түвшинд хүртэл бууруулах, арилгахад чиглэсэн арга хэмжээний зөвлөмж, арга зүйг Монгол улсын стандарт, норм нормативд заасан шаардлагын дагуу тусгаж өгөв.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн 2021-2025 оны стратеги төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.

Компани ISO 14001:2016 байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээр байгаль орчны асуудлуудыг албан ёсоор тодорхойлж тэдгээрийг шийдвэрлэх шат дараатай алхмуудыг бодлогын баримт бичигт тусгасан. Стандартын хүрээнд тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээг бууруулах, үйлдвэрт ашиглах гадаргын ус болон газар доорх усны харьцааг нэмэгдүүлэх, биологийн задралд ордог бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх болон хог хаягдлын дахин боловсруулалтыг сайжруулах замаар байгальд хаях хог хаягдлын хэмжээг бууруулах, хүрээлэн буй орчинд учруулж байгаа сөрөг нөлөөллийг ялангуяа агаар бохирдуулагчийг хянах тогтолцоог олон улсын түвшинд хүргэх, олон талын хэлэлцүүлэгт үндэслэсэн хаалтын бодлогыг бий болгох, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зэрэг гол асуудлуудыг байгаль орчны гол шалгууруудаар тодорхойлсон.

Тус төлөвлөгөө Тавантолгой орд газрын Нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хамаарахын хувьд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн туслан гүйцэтгэгч компаниудад мөрдөгдөнө.

Эдгээр стандарт шаардлага, төлөвлөлт, хариуцлагын хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх ажлыг тус төлөвлөгөөнд тусгав.

2 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Төслийн зорилго, хүчин чадал

“Нүүрс Баяжуулах Үйлдвэр” төсөл нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2021-2026 оны Бизнес төлөвлөгөөний хүрээнд өртөг зардал бууруулах, өрсөлдөх чадвар нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх томоохон зорилт дэвшүүлж байгаа бөгөөд дээрх тогтоол шийдвэрийн дагуу үндэсний их бүтээн байгуулалтын эхлэлийг бий болгож, цаашид сайн чанарын нүүрсний “Тавантолгой” брэнд бүтээгдэхүүн бий болгон олон улсын зах зээлд голлох байр суурь эзлэн аюулгүй, тогтвортой, нээлттэй, хариуцлагатай уул уурхай, үйлдвэрлэл, технологийн цогцолбор паркийг хөгжүүлэх, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хүртээх, шинээр ажлын байр бий болгох, улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах гол зорилготой.

Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний бүлэг ордын ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх болон “Эрдэнэс Тавантолгой” ХК -ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд коксжих чанар султай нүүрсийг сайн чанарын нүүрстэй хольж баяжуулах, чанарыг дундажлан экспортын шаардлага хангасан, орчин үеийн, дэвшилтэт техник, технологи бүхий “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийг богино хугацаанд барьж байгуулах нөхцөлийг хангахад төслийн үндсэн зорилт оршино.

Нүүрс баяжуулах үйлдвэрийг жилд 30.0 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай байхаар хоёр үе шаттай барьж байгуулахаар төлөвлөсөн. Нүүрс баяжуулах үйлдвэр нь ижил хүчин чадалтай, хоорондоо хамааралгүй ажиллах боломжтой тус бүр 10.0 сая.тонн хүчин чадалтай 3 модуль байх ба нэг модулийн үндсэн баяжуулах нь 5.0 сая.тонн хүчин чадалтай бие даасан 2 шугамтай байна.

Нүүрс баяжуулах үйлдвэр (цаашид НБҮ гэх) нь тасралтгүй ажиллагаатайгаар долоо хоногийн 7 өдөр 12 цагаар 2 ээлжээр ажиллах бөгөөд баяжуулах үйлдвэр нь 7 хоногт 1 удаа төлөвлөгөөт зогсолт хийж, засвар үйлчилгээ явуулахаар төлөвлөсөн. НБҮ-ийг 2024 оны 6-р сараас ашиглалтад оруулахаар төлөвлөсөн бөгөөд эхний жилд 5.0 сая тонн, 2024-2025 онд 10.0 сая тонн нүүрс баяжуулна. 2026 оноос баяжуулах үйлдвэрийн 2 ба 3 дахь шугам ашиглалтад орсноор үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллахаар төлөвлөөд байна. НБҮ-ийн ажиллах горим, хүчин чадлыг тооцон Хүснэгт 1-д үзүүлэв.

“Нүүрс Баяжуулах Үйлдвэр” төслийн ерөнхий гүйцэтгэгчээр “Норинко Интернэйшнл Кооперэйшн” ХХК сонгогдон ажиллаж байна.

Хүснэгт № 1. Нүүрс баяжуулах үйлдвэрийн ажиллах горим, хүчин чадал

Үйл ажиллагааны хуваарь	Нэгж	Ашиглалтын жил			
		1	2	3	4
Жилийн календарь хоног	Хоног	183	365	365	365
Өдрийн хуанлийн цаг	Цаг	24	24	24	24
Жилийн хуанлийн цаг	Цаг	4,368	8,760	8,760	8,760
Засвар үйлчилгээний хоног /7 хоногт 1 удаа/	Хоног	26	52	52	52
Жилд бүрэн ажиллах хоног	Хоног	157	313	313	313
Жилд ажиллах боломжит цаг	Цаг	3,768	7,512	7,512	7,512
Цаг ашиглалтын коэффициент	%	0.9	0.9	0.9	0.9
Хоногт ажиллах бодит цаг	Цаг	21.6	21.6	21.6	21.6
Техникийн бэлэн байдлын коэф.	-	0.888	0.888	0.888	0.888
Жилд ажиллах бодит цаг	-	3,011	6,003	6,003	6,003
Үйлдвэрийн хүчин чадал					
Цагийн хүчин чадал /Ad/	т/цаг	1,661	1,661	1,661	5,000
Цагийн хүчин чадал /Ag/	т/цаг	1,794	1,800	1,800	5,400
Хоногийн хүчин чадал	т/хоног	38,753	38,877	38,877	116,631
Жилийн хүчин чадал	т/жил	5,000,000	10,000,000	10,000,000	30,000,000

Төслийн ерөнхий төлөвлөлт

Тус үйлдвэрийг хоёр үе шаттай барьж байгуулахаар төлөвлөсөн бөгөөд нэгдүгээр үе шатанд 10 сая.тн хүчин чадалтай эхний үйлдвэр, хоёрдугаар шатанд 20 сая.тн хүчин чадалтай үлдсэн 2 үйлдвэрүүдийг ашиглалтад оруулах ба тус бүр нь 10 сая.тн нүүрс

боловсруулах хүчин чадал бүхий 3 үйлдвэрийг байгуулна. Нүүрс баяжуулах үйлдвэр нь 2323173, 2323174 нэгж талбарын дугаартай газарт нийтдээ 129,37 га талбайг хамарна. Нүүрс баяжуулах үйлдвэр нь дараах байгууламжуудаас бүрдэнэ. Үүнд:

- Түүхий нүүрс хадгалах байгууламж
- Бүтээгдэхүүн хадгалах байгууламж
- Нүүрс бутлах, шигшиж ангилах байгууламж
- Нүүрс угаах байгууламж
- Бүтээгдэхүүн, хаягдал усгуйжүүлэх байгууламж
- Бүтээгдэхүүний хаягдал хадгалах байгууламж
- Эргэлтийн усан сан
- Цэвэр усан сан
- Хаягдлын овоолгын талбай
- Технологийн зам талбай
- Авто машинд нүүрс ачих байгууламж
- Вагонд нүүрс ачих байгууламж
- Уурын зуух
- Автожингийн байр
- Бохир хуримтлуулах байр
- Хог хаягдлын цэг
- Туслан гүйцэтгэгч компаниудын барилга, байгууламж
- Химийн бодис, шатах туслах материалын цэг
- Аж ахуйн хэсгээс бүрдэнэ.



Зураг № 1. “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн ерөнхий төлөвлөлт

Ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч байгууллагуудын мэдээлэл

Хүснэгт № 2. Туслан гүйцэтгэгч компаниудын мэдээлэл

Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байгууллагын хаяг
“Норинко Интернэйшнл Кооперэйшн” ХХК	Үндсэн гүйцэтгэгч	Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 15-р хороо, Хаан тауэр 23 давхар 2303 тоот
“Баяас Прайм Инженеринг” ХХК	Туслан гүйцэтгэгч - барилга	УБ, ХУД 18-р хороо, Академи сентер, 3 давхар
“Билгүүн Монгол Констракшн” ХХК	Туслан гүйцэтгэгч - барилга	Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 23-р хороо, 876 тоот
“Дулаан Баян Говь” ХХК	Бетон зуурмагийн үйлдвэр	Өмнөговь аймаг, Даланзадгад, 3-р баг Далан, Говь Сэндс төв 306 тоот

3 ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1 Уур амьсгал

Цогтцэций сумын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -14.8°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 41.3°C хүрдэг байна. Хөрсний гадаргын дундаж температур нь ойролцоогоор 8.0°C .

Жилийн дундаж агаарын температур нь 0.9°C , хамгийн хүйтэн I сарын дундаж температур -14.6°C бол хамгийн дулаан сар болох VII сарын дундаж температур 23.1°C байдаг байна.

Цогтцэций суманд жилд дунджаар 76.7 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 52.7 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 68 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна.

Салхины зонхлох чиглэлийн хувьд манай ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд баруун хойноос нийт салхины чиглэлийн 38.8%, баруунаас 20.7%, баруунаас 9.4% давтагдалтай байдаг.

Салхины хурдны олон жилийн дундаж нь ойролцоогоор 5.1 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул салхины хурд багасдаг боловч зарим жил 34 м/с хүрч шороон болон цасан шуурга шуурч байсан тохиолдол цөөнгүй.

3.2 Геоморфологи

Гадаргуугийн хувьд ерөнхийдөө нам уулс, жижиг толгод, талархаг гадаргуу зонхилох ба далайн түвшнээс дээш 1490-1590 м өргөгдсөн. Хамгийн өндөрлөг цэгүүд нь Таван толгойн талбайгаас баруун урагш орших Бага уул /1731.1 м/, зүүн хойно байх Майга улаан уул /1587.5 м/, чанх урагш орших Нэргүй өндөрлөг /1652.2 м/, зүүн урагш байх Таван толгой уул /1570 м/ зэрэг болно. Хамгийн нам цэгүүдэд Улаан нуур болон бусад нуур тойрмуудын хөндий орно. Голын хөндийнүүд нь ерөнхийдөө өргөргийн чиглэлтэй ба элсэрхэг, шаварлаг хурдсаар дүүргэгдсэн байдаг. Физик газар зүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газар зүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтана.

Гадаргуу нь гарал үүслийн шинж чанараа денудацийн буюу зөөгдлийн, структур-денудацийн, эрози-денудацийн буюу элэгдэл-зөөгдлийн, денудаци-хуримтлалын бүрдэлд хуваагддаг.

3.3 Хөрс

Хөрс газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Говийн мужийн Говийн цайвар бор, Цөлийн бор саарал хөрс бүхий 12-р тойрогт (Манлайн хөрсний тойрогт) багтана. Говийн цайвар бор зонхилон тархах бөгөөд урд хэсгээр Цөлийн бор саарал хөрстэй. Ерөнхий хөрсөн бүрхэвч нь доворхог хад чулуурхаг газрын гадаргын байдлаас шалтгаалж алаг цоог, хоршил зонхилно. Өндөрлөгдүү газраар нимгэн чулуурхаг, хотгордуу газраар ердийн Говийн цайвар бор хөрстэй. Лицензийн талбайн хойд хэсгээр нимгэн чулуурхаг хөрстэй байхад, урд хэсгийн хотгордуу газраар элсэрхэг дов ихтэй элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нилээд их талбай эзэлж байна. Хотгордуу газраар мараалаг хужирлаг шинжийн давсархаг хөрс хам бүрдэл үүсгэж бага зэрэг талбай эзэлнэ.

3.4 Ургамлан бүрхэвч

“Нүүрс баяжуулах үйлдвэр” төсөл нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт, ландшафт-экологийн мужлалаар Дундад говийн муж, Даланзадгадын районд гүвээ толгод бүхий уудам хөндий, хужир марцтай хотгор, цөлөрхөг хээрийн ургамал зонхилсон газар юм. Ургамал бүрхэвч нь газрын гадаргын байдал, хөрсний бүтэц, усан хангамжаас шалтгаалан

таана-баглуурт, таана-хялгана, бор бударгана, улаан бударгана зэрэг эвшил бүлгэмдэлээс бүрдэх бөгөөд алтан харгана, дэрс, загсгал, догар, хотир зэрэг сөөг олон наст болон нэг наст өвслөг ургамлууд оролцдог байна. Нийтдээ 13 овгийн 51 төрлийн 75 зүйлийн бүрдэлтэй байна.

3.5 Нийгэм, эдийн засаг

Өмнөговь аймаг нь 2019 оны байдлаар нийт 113,349 хүн бүртгэгдсэнээс Цогтцэций суманд 8119 хүн бүртгэгдсэн байна. Уурхайн талбайтай хамгийн ойр орших суурин газар нь Цогтцэций сум юм. Тус сум нь Монгол улсын өмнөд хилээс 240 км, аймгийн төвөөс 100 км, нийслэл Улаанбаатар хотоос 540 км-т алслагдсан бөгөөд өмнө талаараа Баян-Овоо, баруун талаараа Ханхонгор, хойд талаараа Цогт-Овоо, Дундговь аймгийн Өлзийт сумтай, зүүн талаараа Манлай сумтай тус тус хил залгана.

Хүснэгт 1. 2021 оны хүн амын тоо

Үзүүлэлт	Өмнөговь аймаг	Цогтцэций сум
Хүн амын тоо	72943	8599
Эрэгтэй	36881	4390
Эмэгтэй	36062	4209
Өрхийн тоо	23164	2643

Өмнөговь аймаг нь 2021 оны байдлаар 2513.8 мян тоо толгой мал тоологдсоноос Цогтцэций суманд 151.65 мян толгой мал тоологдсон байна.

Хүснэгт 2. 2021 оны мал тоо


Аймаг, сум	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Өмнөговь	2513.81	102.02	31.28	160.58	626.71	1593.2
Цогтцэций	151.65	10.57	2.18	3.52	53.73	81.66

Цогтцэций сум нь Өмнөговь аймгийн 15 сум дотроо хамгийн бага буюу 700 гаруй га газар нутагтай. Түүний 16% нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Үүнээс төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХК нь Тавантолгойн бүлэг ордод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр төсөл жилдээ 20 сая.тн нүүрс олборлон экспортлож байна. Мөн хөрс хуулалт, тээврийн үйл ажиллагаанд 20-30 туслан гүйцэтгэгч гэрээт компаниуд оролцон үйл ажиллагааны эрчимд нөлөөлж байдаг.

Мөн 2019 оноос Улаанбаатар хотыг утаагүй болгох ажлын хүрээнд 100 орчим хүнд даацын машинууд нүүрс тээвэрлэж, зам дагуу нутагладаг малчдын бэлчээрийг талхалж, тоосжилт үүсгэн, өдөр шөнөгүй тээвэр хийж байна. Мөн замын дагуух худаг усыг бохирдуулах, хог хаягдал үүсгэх, зогссон газраа засвар үйлчилгээ хийж тос тосолгооны материалын асгаралтыг үүсгэж нь байгаль орчинд маш их нөлөө үзүүлж байна. Тус сумаас хот хоорондын төв зам хүртэл 59.6 км шороон зам байдаг нь үүнд нөлөөлж байна.

3.6 Төслийн талбайн байршил

Төслийн талбай нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст буюу 1-р багийн нутаг дэвсгэрт Улаанбаатар хотоос 540 км, аймгийн төв Даланзадгад хотоос зүүн зүгт 90 км, Цогтцэций сумын төвөөс зүүн өмнө зүгт 7 км зайд байрлана.



0 1.25 2.5 5 Kilometers
Coordinate System: WGS 1984 UTM Zone 48N
Projection: Transverse Mercator
Datum: WGS 1984



ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН
УУРХАЙН БАЙРЗҮЙН ЗУРАГ

Огноо 2020-07-04
Зургийн хувилбар №1
Масштаб М1:100 000

Зураг № 2. "Нүүрс баяжуулах үйлдвэр" төслийн байршлийн зураг

Хүснэгт № 3. "Нүүрс баяжуулах үйлдвэр" төслийн талбайн хэмжээ

№	Аймаг, сум	Нутаг дэвсгэрийн хэмжээ, га
1	Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Сийрст баг	129,37

4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэ бүлгийн зорилго нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн захиалгаар ерөнхий гүйцэтгэгч “Норинко Интернэйшнл Кооперэйшн” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Нүүрс Баяжуулах Үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлж, дүн шинжилгээ хийж, тодорхойлон тооцоход оршино. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн захиалгаар “Хатандалай” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Тавантолгойн Ордыг Түшиглэн Байгуулагдах “Үйлдвэр Технологийн Парк” -ийн Хүрээнд Хэрэгжих “Нүүрс Баяжуулах Үйлдвэр” -ийн Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээний Тайлан (цаашид БОННУ гэх) -д тусгасан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг баримталлаа. БОННУ-д төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг их нөлөөлөл 11.6%, дунд зэргийн нөлөөлөл 23.5%, бага нөлөөлөл 31.5%, нөлөөлөлгүй 33.4% гэж үнэлсэн ба дунджаар орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд дунд зэргийн нөлөөлөл үзүүлнэ гэж дүгнэжээ. Хамгийн их сөрөг нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн хэсэг нь агаар болон хөрсөн бүрхэвч юм.

4.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц

ISO 14001:2016 стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийсэн. Байгаль орчны асуудлыг тодорхойлж эдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлсон. Нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон

Хүснэгт № 4. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				
	ялимгүй	бага	дунд	их	гамшиг
I бараг болохгүй	L	L	M	H	H
II магад болохгүй	L	L	M	H	E
III болзошгүй	L	M	H	E	E
IV магад болох	M	H	H	E	E
V лавтай болох	H	H	E	E	E

Хүснэгт № 5. Магадлалын үнэлгээний шалгуур

Түвшин	Зэрэг	Тайлбар
I	Бараг болохгүй	Онцгой нөхцөлд эрсдэлтэй байж магадгүй (<5%)
II	Болохгүй байж магад	Заримдаа эрсдэлтэй байж магадгүй (5-20%)
III	Болзошгүй	Заримдаа эрсдэл үүснэ (20-50%)
IV	Магад болох	Бараг бүх нөхцөл эрсдэл үүсгэж болзошгүй (50-70%)
V	Лавтай болох	Бараг бүх нөхцөл эрсдэлтэй (70-100%)

Хүснэгт № 6. Үр дагаварын үнэлгээний шалгуур

Зэрэглэл	Уршиг	Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт		Уршигийг бууруулах арилгах шийдэл
		Хүн ам	Эд хөрөнгө	
I	Ялимгүй	Техноген нөлөө арилахад хор уршиг арилна	Хохирол үгүй	Тусгай шийдэл шаардлагагүй
II	Бага	Бүс нутагт хуримтлагдах нөлөөлөл бий болгож био орчинд стресс учруулна	Багавтар хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн горимыг мөрдөх
III	Дунд	Урт хугацаанд дэлхийн дулааралд хувь нэмэр оруулна	Дунд зэрэг хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн чанд горимыг мөрдөх, зохион байгуулалтын өндөр түвшинд ажиллах
IV	Их	Хуримтлагдах сөрөг нөлөө үүсгэж урт хугацаанд экологийн тэнцвэр алдагдана	Их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил, Тодорхой хэмжээний хөрөнгө зардал шаардана
V	Гамшиг	Байгаль орчинд эргэж буцахааргүй уршиг учруулж экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ	Маш их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил. Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана

Үйл ажиллагаа	Асуудал	Нөлөөлөл	Магадлал	Үр дагавар	Эрсдэлийн зэрэглэл	Хариу арга хэмжээ
1	2	3	4	5	6	7
Ажилчдын хотхон	Дулаан түгээх	Хүлэмжийн хий үүснэ	4	1	II	Мод тарих
			4	1	II	Гүлш зарцуулалтын хяналт
	Их хэмжээний хог хаягдал	Лэндфилийн талбай нэмэгдэнэ	5	4	IV	Хог хаягдлын ангилан ялгалт
			5	4	IV	Хог хаягдлын гарцыг хянах
Барилга шинээр байгуулах	Газар шорооны ажил	Тоосжилт	4	3	III	Тоос бууруулах арга хэмжээ
		Хөрсний эвдрэл	4	3	III	Хөрсний өөрчлөлтийн хяналт
			4	3	III	Хөдөлгөөний хязгаарлалт
Засвар, угсралт эрхлэх	Ашигласан сэлбэг, хэрэгсэл хаягдана	Хөрсний бохирдол	4	4	IV	Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт
			4	4	IV	Хог хаягдлын гарцыг хянах
			4	4	IV	Ажлын байрны тогтмол үзлэг
	Бохирлогдсон материал хаягдах		4	3	III	Аюултай бодисын удирдлага
			4	3	III	Хөрсний бохирдлын хяналт
	Тос, шинэгн материал хаягдана		4	4	IV	Асгаралтаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө
			4	4	IV	Хөрсний бохирдлын хяналт
	Химийн бодисийн алдагдал		4	4	IV	Асгаралтаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө
			4	4	IV	Аюултай бодисын хяналт, бүртгэл
			4	4	IV	Ажлын байрны эмх цэгц

5 СӨРӨГ НӨЛӨӨЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Газрын гадарга, хэвлий

Төслийн барилгын ажлын үед шатах тослох материал алдагдах, хог хаягдлын менежментийг хангалтгүй хийснээс хог хаягдлаар бохирдох, газрын гадарга эвдрэлд орох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй. Тус талбай нь хойноосоо урагш уртрагийн дагуу сунаж тогтсон учир хотгор гүдгэрийн хувьд дундаж өндөр, нам уулс, цав толгод, хөндий хотгор хосолсон бөгөөд ерөнхийдөө долгиорхог тэгш гадаргатай.

Агаарын чанар

Төсөлд ашиглах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр түр зам, талбайгаас тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлж болзошгүй. Мөн төсөлд ашиглах техник хэрэгслүүдээс

нүүрсхүчлийн хий, хүхэрлэг хий, азотын исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл ялгарч, агаарын чанарын найрлагад түр хугацаанд бага хэмжээгээр нөлөөлнө.

Уур амьсгал

Төслийн талбайд ашиглах техник хэрэгслүүдээс хүлэмжийн хийн гол бүрэлдэхүүн болох нүүрсхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг бага хэмжээгээр нэмэгдүүлнэ.

Гадаргын болон газрын доорх ус

Төслийн талбайд ажиллах тээврийн хэрэгслүүдэд эвдрэл, гэмтэл гарсан үед болон ажилчдын санамсар болгоомжгүй байдал, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс гэнэтийн осол гарч шатах тослох материал асгарсан тохиолдолд хөрс бохирдож, улмаар хур тунадас орсон үед үерийн усаар дамжин гадаргын түр урсац болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.

Ургамлан нөмрөг

Төсөл хэрэгжүүлэх талбай, барилгын ажилд ашиглагдах түр зам, кемп байгуулах газрууд бүтээн байгуулалтын үед нөлөөлөлд өртөнө. Бүтээн байгуулалтын дараа “Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын төлөвлөгөө”-ний дагуу нөлөөлөлд өртсөн талбай, газруудыг холбогдох стандартын дагуу нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Амьтны аймаг

Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймагт дараах нөлөөлөл, үр дагаврууд бий болж болзошгүй. Төслийн үндсэн үйл ажиллагаа хөрс шүтэн амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчид болон шавжийн зүйлийн бүрдэл, тоо толгойг бууруулах, амьдрах орчныг алдагдуулах сөрөг нөлөө үүсэх магадлалтай. Хөрсний эвдрэл, доройтол, орчны тоосжилтын улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурах нөлөөлөл гарч болзошгүй. Төслийг хэрэгжүүлэх явцад амьтдын амьдрах орчин өөрчлөгдөж, шинээр бий болсон орчинд тухайн нутагт өмнө нь тохиолдож байгаагүй, эсвэл тоо толгой нь цөөн байсан амьтад олноор шилжин суурьшиж болзошгүй тул амьтдын унаган амьдрах орчныг бүрдүүлэх, амьтны төрөл зүйлийг сэргээхэд анхаарах шаардлагатай.

Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбай нь дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газарт хамаарахгүй тул тэдгээр газруудад шууд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй байна.

Дуу шуугиан

Төслийн бүтээн байгуулалтын үед төслийн талбайд ажиллах тээврийн хэрэгслээс үүдэлтэй дуу шуугиан үүсч болзошгүй. Төсөл хэрэгжих талбайд дуу шуугианы хэмжилтийн хамгийн их утга нь 77.5 дБа, дундаж нь 53 дБа, хамгийн бага утга нь 39.2 дБа байна.

Нийгэм, эдийн засаг

Үйлдвэрийн бүс, овоолгын үйл ажиллагаанаа үүсэх тоосжилт төслийн талбайн ойролцоох нөлөөллийн бүсэд хамрагдах малчин өрх, байгаль орчинд нөлөөлөх магадлалтай. БОННУ-нд төслийн талбайгаас 3 км радиус дотор байгаа айлыг нөлөөллийн бүс гэж үзнэ гэж тусгасан.

Түүх, соёлын дурсгалт зүйлс

Төслийн талбай болон түүний ойр орчимд түүх, соёлын дурсгалт зүйлс өнөөгийн байдлаар тодорхойлогдоогүй байна. Энэхүү төсөл хэрэгжүүлэх явцад мэдэгдээгүй түүх дурсгалын зүйлс, булш, бунхан хиргисүүр, археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд түүх соёлын үнэт өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагаагаа зогсоож хамгаалалт гарган зохих хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, улмаар тухайн газар нутгийг бүрэн хамгаалалтанд авах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай.

Хог хаягдлын менежмент

Түр кемп, төслийн талбайд ажиллаж буй ерөнхий болон туслан гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанаас аюултай болон ахуйн хог хаягдлууд үүсч санамсар болгоомжгүй байдлаас үүдэн хаягдал асгарч алдагдсанаас болж хүрээлэн буй орчныг бохирдуулж болзошгүй.

Төслийн барилга, байгууламжуудын үйл ажиллагааны үед бий болох хаягдал, тэдгээрийн устгал, зайлуулалтын улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх замаар үр ашигтай зохион байгуулж, бууруулж болно. Энэ нь төслийн байгаль орчны менежментийн чухал хэсэг болно.

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр							
6.1.1	Барилгын ажлын талбайгаас болон шороон замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах	Барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг дарахын тулд зам, талбайг услах.	Төслийн талбай	Тогтмол	3-10 сард	Үйл ажиллагааны зардал	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл, Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016)
6.1.2	Дэгдэмхий органик нэгдэл агаарт уурших	Түр ашиглах био 00, ариун цэврийн байгууламж байгуулах	Кемп байгуулах талбайд	1 ш	Жилдээ	4,500,000	
6.1.3	Нянгийн бохирдолоос үүдэлтэй органик нэгдлүүд агаарт дэгдэх	Ахуйн шингэн хаягдлын танкийг газрын хөлдөлтийн гүнээс доош суулгах	Кемп байгуулах талбайд	1 ш	Жилдээ	15,000,000	
6.1.4		Цэвэрлэх байгууламжтай ААН-д гэрээгээрээ шингэн хаягдлаа нийлүүлэх		Сар бүр	12	12,000,000	
6.1.5	Хог хаягдлаар орчны бохирдол үүсэх	Хог хаягдлын цэг байгуулах	Кемп байгуулах талбайд	ш	Жилдээ	2,500,000	
6.2 Газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр							
6.2.1	5280 м ³ өнгөн хөрс хуулж овоолго үүсгэн газрын гадарга өөрчлөгдөнө.	Өнгөн хөрсний овоолгыг 2 жил ашиглахгүй бол стандартын дагуу хадгалах	Төслийн талбай	5000 м ³	Жилдээ	Үйл ажиллагааны зардал	Газрын тухай хууль
6.2.2	Цогтцэций сумаас НБҮ хүртэлх 5-7 км-ийн тээврийн замын трассын дагуу 1.5-2.1 га газар зам үүсэж, газрын гадарга эвдэрнэ.	Замын маршрутын батлуулж зөвхөн батлагдсан маршрутаар зорчих.	Төслийн талбайд	-	-	Үйл ажиллагааны зардал	

6.3 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр							
6.3.1	5280 м ³ өнгөн хөрс хуулж эвдрэл үүсгэнэ.	Шимт хөрс хуулах зөвшөөрөл, Газар хөндөх зөвшөөрлийн дагуу мэдээллийн сан үүсгэх, шимт хөрсний овоолгыг нимгэн материалаар хучих туршилт хийх	Шимт хөрсний овоолго	5000 м ³	Жилдээ	18,000,000	MNS4920:2000, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
6.3.2	ТТАМ-ийг зөвшөөрөлгүйгээр ашиглах	Тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-аас ТТАМ-ийг ашиглах, гэрээ, бичиг баримтын бүрдлийг хангах	Төслийн талбайд	-	-	-	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
6.4 Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр							
6.4.1	Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорх усны нөөц хомсдох	Барилгын ажилд ус авч ашиглах гүний худгыг тоолууржуулах	Төслийн хэмжээнд	2 ш	Сар бүр тоолуурын заалтыг баталгаажуулж байх	500,000	MNS0900:2018-Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.
6.4.2		Төслийн талбайд ойр байрлах гүний худгийг зөвшөөрлийн дагуу ашиглаж, ус ашиглуулах дүгнэлт гаргуулах, гэрээ байгуулах	Төслийн талбайд	1 ш	2-р улиралд багтаан	-	
6.4.3	Гүний ус бохирдох	Худгийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг сахиулах	Худаг	1	Жилдээ	Үйл ажиллагааны зардал	
6.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр							
6.5.1	Амьтны амьдрах орчин доройтох, хязгаарлагдах	Кемп болон НБУ-ийн ойр орчимд харагдаж буй амьтдыг тэмдэглэх	бүс нутгийн хэмжээнд	Өдөр бүр	-	Үйл ажиллагааны зардал	Амьтны тухай хууль
6.5.2		Хөнжлийн нуруунд амьтдын нүүдлийн трассуудыг тогтоох, камержуулах /аргал болон цагаан зээр очих магадлалтай нутаг/	бүс нутгийн хэмжээнд	-	Жилдээ	8,000,000	

7. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 9. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө

Бүлэг	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал, сая ₮	Эрх зүйн баримт бичиг
7.1.1	Ажиллагсадын түр кемпийн орчим 0.01 га- д мод тарих	Ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор модлог ургамлыг тарих, арчлах	Төслийн талбайд	ш	5000	5 болон 10-р сард	24,800,000	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль MNS 5915:2008 MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
7.1.2	Барилгын ажлын талбайн шимт хөрс хуулах	Шимт хөрсийг зөөвөрлөх, стандартын дагуу овоолго үүсгэх	Барилгын суурийн талбай, техник тоног төхөөрөмж	Хуулсан хэмжээгээр	-	Тухай бүрт	70,000,000	

8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 10. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Бүлэг	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Эрх зүйн баримт бичиг
8.1.1	Шууд хамгааллын арга хэмжээ	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах байршлыг тодорхойлох	Дүйцүүлэн хамгаалахаар сонгосон талбайд	-	6,667,462.5	6,667,462.5	Жилийн турш	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
8.1.2		Сонгогдсон байршилд суурь судалгааг хийх		-				
8.1.3		Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх		-				

9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 11. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Бүлэг	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал	Баримтлах эрх зүйн баримт бичиг
9.1 Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр								
9.1.1	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Төслийн талбай	хүн	>50 хүнд	Өдөр бүр	5,000,000	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль
9.1.2	Гал түймрийн улмаас төслийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн талбай	Улирал бүр	>50 хүнд	Улиралд 1 удаа	1,000,000	Галын аюулгүй байдлын тухай хууль
9.1.3		Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	Төслийн талбай	1 ш	Хэрэгцээтэй хэмжээгээр	Тухай бүрт	15,000,000	
9.2 Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр								
9.2.1	Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Төслийн талбай	хүн/өдөр	-	Улиралд 1 удаа	Үйл ажиллагааны зардлаас	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Бүлэг	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Нийт зардал, сая ₮	Баримтлах эрх зүйн баримт бичиг
10.1.1	Ахуйн	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Төслийн талбайн хэмжээнд	-	Улирал	Үйл ажиллагааны зардал	Хог хаягдлын тухай хууль
10.1.2	Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай хаяхгүй байх, зориулалтын битүү саванд ангилан ялгаж, хадгалах дахин ашиглах болон үйлдвэрлэгчид нийлүүлэх	Төслийн талбайн хэмжээнд	-	Улирал	Үйл ажиллагааны зардал	Хог хаягдлын тухай хууль
10.1.3	Энгийн	Тусгай зөвшөөрөлтэй ААНБ-тай гэрээ байгуулах, нийлүүлэх	Төслийн талбайн хэмжээнд	-	Улирал	Үйл ажиллагааны зардал	Хог хаягдлын тухай хууль
10.1.4	Бүгд	Стандартын шаардлага хангасан хогийн түр цэг байгуулах	Төслийн талбайн хэмжээнд	-	Тухай бүрт	Үйл ажиллагааны зардал	Хог хаягдлын тухай хууль

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт № 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Бүлэг	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, ₮	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
11.1 Агаарын чанар								
11.1.1	Гадаад орчны PM2.5, PM10 болон нийт тоосны хэмжилт хийх	3 цэгт	Хагас жил тутам	2	40,000	2,400,000		MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
11.1.2	Гадаад орчны агаарын найрлага дахь SO ₂ , CO, NO ₂ хийнүүдийг хэмжих	3 цэгт	Хагас жил тутам	2	40,000	2,400,000		MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
11.1.3	Дуу шуугиан (гадаад орчны дуу шуугианы түвшин)	3 цэгт	Хагас жил тутам	2	40,000	2,400,000		MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
11.2 Хөрсөн бүрхэвч								
11.2.1	Хөрсөн дэх хүнд металлын агууламж	3 цэгт	Хагас жил тутам	2	55,000	3,300,000		MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
11.2.2	Агрохими	3 цэгт	Хагас жил тутам	2	22,000	1,320,000		
11.2.3	Нянгийн бохирдол	3 цэгт Гал тогоо, цэвэрлэх байгууламж, захиргаа	Хагас жил тутам	2	100,000	1,200,000		

11.3 Усан орчин							
11.3.1	Усан дахь эрдэс бодисууд, химийн найрлага	4 цэгт	Улирал тутам	1	56,000	1,792,000	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
11.3.2	Усны хүнд металлын шинжилгээ	4 цэгт	Жилд	1	98,800	3,160,000	
11.3.3	Микробиологи	4 цэгт	Жилд	1	98,300	3,145,600	
11.4 Ургамлан бүрхэвч							
11.4.1	Ургамлын мониторинг	15 цэгт	Жилд	1	1,500,000	3,000,000	Ургамлын тухай хууль
11.5 Амьтны аймаг							
11.5.1	Амьтны мониторинг	15 цэгт	Жилд	1	1,500,000	3,000,000	Амьтны тухай хууль

12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ба зардал

Бүлэг	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хариуцах эзэн
12.1	Байгаль хамгаалах ажлын барьцаа хөрөнгө төвлөрүүлэх	ТЖБОМТ-д тусгасан зардал	Үйл ажиллагааны зардал	Жил бүр	Байгаль орчны асуудал хариуцсан нэгж
12.2	Тухайн жилийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрх бүхий байгууллагад тайлагнах	Үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны зардал	Жил бүрийн 11-12 дугаар сард	Байгаль орчны асуудал хариуцсан нэгж

Бүлэг	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хариуцах эзэн
12.3	Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах	Үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны зардал	Жил бүрийн эхний улиралд багтаан	Байгаль орчны асуудал хариуцсан нэгж
12.4	Байгаль орчны хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчны дотоод хяналтыг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хүрээнд	8,000,000	Жил бүр	Дотоод хяналтын нэгж

13. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 15. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

Бүлэг	Оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Нийт зардал, сая ₮	Хариуцах ажилтан	Зохион байгуулах газар
13.1	Сумын иргэд	Уулзалт, ярилцлага	БОМТ танилцуулах хурал	10-р сар	800,000	Байгаль орчны мэргэжилтэн	Цогтцэций сумын соёлын төв
13.2	Нөлөөллийн бүсийн иргэд, сумын удирдлага, мэргэжилтэнүүд	Уулзалт, ярилцлага	Үйл ажиллагааг танилцуулах	Жилд 2 удаа	800,000	Холбогдох хэлтэс нэгж, туслан гүйцэтгэгч нар	Цогтцэций сумын соёлын төв

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ

Хүснэгт № 16. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв

№	БОМТ ангилал	Төсөв, мян₮
1	Нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа	60,500,000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	94,800,000
3	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	6,667,463
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	21,000,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	-
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	27,117,600
7	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	8,000,000
8	Оршин суугч, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	1,600,000
Нийт		219,685,063

ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР

Тухайн ажилд шаардагдах хөрөнгө зардал, нөөц, цаг хугацаа, сөрөг нөлөөллийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан ач холбогдолын эрэмбэ зохиож эзлэх жинг тодорхойлсон болно.

Бүлэг	Бүлгийн нэр	Төлөвлөсөн ажил	Шалгуур	Эзлэх жин
6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө				
6.1.1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Зам талбайг усалж тоосжилтыг дарах	Тоосны түвшинг хамгийн бага байлгах түвшинд усалгааг хийнэ.	1
6.1.2		Түр ашиглах био 00, ариун цэврийн байгууламж байгуулах	Баяжуулах үйлдвэрийн кемпийн хэрэгцээнд 1 байршилд хийнэ.	1
6.1.3		Ахуйн шингэн хаягдлын танкийг газрын хөлдөлтийн гүнээс доош суулгах	Цэвэрлэх байгууламжийн саарал усыг цуглуулах контейнер 1 ш-г байрлуулна.	1
6.1.4		Цэвэрлэх байгууламжтай ААН-д гэрээгээрээ шингэн хаягдлаа нийлүүлэх	Зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан байна.	1
6.1.5		Хог хаягдлын цэг байгуулах	Хог хаягдлын түр цэгийн зөвшөөрлийн үндсэн дээр байгуулсан байна.	1
6.2.1	Газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Өнгөн хөрсний овоолгыг 2 жил ашиглахгүй бол стандартын дагуу хадгалах	Өнгөн хөрстэй ажиллах журмын дагуу хуулж хадгалсан байна.	1
6.2.2		Замын маршрутын батлуулж зөвхөн батлагдсан маршрутаар зорчих.	Сумын цагдаагийн газраар маршрут батлуулан мөрдүүлж ажиллана.	1
6.3.1	Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Шимт хөрс хуулах зөвшөөрөл, Газар хөндөх зөвшөөрлийн дагуу мэдээллийн сан үүсгэх, шимт хөрсний овоолгыг нимгэн материалаар хучих туршилт хийх	Овоолго үүсгэсэн шимт хөрсний овоолгыг байгалийн үзэгдэл нөлөөлөлд өртүүлэхгүй байхар тооцоолж хучих туршилтыг хийх.	1
6.3.2		Тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-аас ТТАМ-ийг ашиглах, гэрээ, бичиг баримтын бүрдлийг хангах	Бүх бичиг баримтын бүрдлийг бүрэн хангана.	2

6.4.1		Барилгын ажилд ус авч ашиглах гүний худгыг тоолууржуулах	Ашиглаж буй худгуудыг бүрэн тоолууржуулж баталгаажуулна.	1
6.4.2	Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Төслийн талбайд ойр байрлах гүний худгийг зөвшөөрлийн дагуу ашиглаж, ус ашиглуулах дүгнэлт гаргуулах, гэрээ байгуулах		2
6.4.3		Худгийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг сахиулах.	Эрүүл ахуйн бүс тогтоосон захирамжийг гаргуулж хэрэгжилтийг хангуулна.	2
6.5.1	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Кемп болон НБҮ-ийн ойр орчимд харагдаж буй амьтдыг тэмдэглэх	Тэмдэглэл хөтөлсөн байна.	2
6.5.2		Хөнжлийн нуруунд амьтдын нүүдлийн трассуудыг тогтоох, камержуулах /аргал болон цагаан зээр очих магадлалтай нутаг/	2 байрлалд автомат камер байрлуулна.	3
				20
7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө				
7.1.1	Ажиллагсадын түр кемпын орчим 0.01 га- д мод тарих	Ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор модлог ургамлыг тарих, арчлах	5000 ширхэг модлог ургамлыг тарьж арчилна.	15
7.1.2	Барилгын ажлын талбайн шимт хөрс хуулах	Шимт хөрсийг зөөвөрлөх, стандартын дагуу овоолго үүсгэх	Хуулсан шимт хөрс бүрийг алдагдалгүй зөөвөрлөж овоолсон байна.	15
				30
8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө				
8.1	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажил	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах байршлыг тодорхойлох	Аймгийн БОАЖГ болон Сумын ЗДТГ-аас санал авч газар нутгийг тогтоосон байна.	5
8.2		Сонгогдсон газарт суурь судалгаа хийх.	Сонгогдсон нутагт уст цэг, амьтан, ургамлын суурь судалгааг хийсэн байна.	3
8.3		Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх	Тэндэр шалгаруулалт явуулж гүйцэтгэгч сонгогдсон байна.	2
				10
9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө				
9.1.1	Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Урьдчилсан мэдээллийг тогтмол авч үйл ажиллагаанд ашиглах.	3
9.1.2		Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Улирал тутас 50-иас багагүй хүнд сургалт орж мэдлэг олгосон байна.	2
9.1.3		Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор	Галын сараа, гал унтраагуурыг хангалттай	2

		зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	хэмжээгээр байрлуулсан байна.	
9.2.1	Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хэрэглээнд байнгын хяналт хийж ажиллана.	3
				10
10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө				
10.1.1	Ахуйн хог хаягдал	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Хог хаягдлын ангилан ялгалтыг байнгын хийж ашиглагдах боломжгүй хог хаягдлыг хамгийн бага түвшинд байлгана.	2
10.1.2	Үйлдвэрийн хог хаягдал	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай хаяхгүй байх, зориулалтын битүү саванд ангилан ялгаж, хадгалах дахин ашиглах болон үйлдвэрлэгчид нийлүүлэх	Хог хаягдал цуглуулах савыг хангалттай хэмжээгээр байрлуулсан байна.	3
10.1.3	Энгийн хог хаягдал	Тусгай зөвшөөрөлтэй ААНБ-тай гэрээ байгуулах, нийлүүлэх	Дахин ашиглах хог хаягдал нийлүүлэх гэрээ байгуулан тогтмол нийлүүлнэ.	2
10.1.4	Бүгд	Стандартын шаардлага хангасан хогийн түр цэг байгуулах	Хог хаягдлын түр цэгийн зөвшөөрөл авч байгуулна.	3
				10
11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр				
11.1.1	Агаарын чанар	Аэрозол: PM2.5, PM10, нийт тоосонцор	Жилийн турш 50 цаг/жил хүчинтэй хэмжилтийг хийж гүйцэтгэсэн байна.	1
11.1.2		Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ	Жилд 2 удаа хэмжилт хийсэн байна.	1
11.1.3		Дуу чимээний хяналт	Жилд 2 удаа буюу намар, өвлийн улиралд 3 цэгт хэмжилт хийсэн байна.	1
11.2.1	Усны чанар	Усны хими, физикийн ерөнхий шинжилгээ	4 худагт жилд 4 удаа шинжилгээ хийлгэсэн байна.	1
11.2.2		Усны хүнд металлын шинжилгээ	4 худагт жилд 1 удаа шинжилгээ хийлгэсэн байна.	1
11.2.3		Микробиологи	4 худагт жилд 1 удаа шинжилгээ хийлгэсэн байна.	1
11.3.1	Хөрсөн бүрхэвч	Хөрсний агрохимийн үзүүлэлт	3 цэгээс жилд 2 удаа	1
11.3.2		Ерөнхий хими, физик	3 цэгээс жилд 2 удаа	1
11.3.3		Хөрсөн дэхь хүнд метал	3 цэгээс жилд 2 удаа	1
11.4.1	Ургамлан нөмрөг	Ургамлын мониторинг	Жилд 1 удаа 15 цэгт хийнэ.	0.5
11.5.1	Амьтны аймаг	Амьтны мониторинг	Жилд 1 удаа 15 байрлалд хийнэ.	0.5
				10
12. Удрдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө				

12.1	БОМТ-ний барьцаа хөрөнгө байршуулах	БОМТ-ний барьцаа хөрөнгийг 100 хувь байршуулсан байна.	2
12.2	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг ажлын хэсгээр дүгнүүлэх	БОМТ-ийн биелэлтийн тайланг Өмнөговь аймгийн БОАЖГ-аар дүгнүүлсэн байна.	1
12.3	Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах	БОМТ-г БОАЖЯ-аар батлуулсан байна.	1
12.4	Байгаль орчны хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчны дотоод хяналтыг хэрэгжүүлэх	Дотоод хяналтын нэгжийн шалгалт хийсэн тайлангаар	1
			5
13. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө			
13.1	Багийн иргэд	Багийн иргэдэд БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнасан байна.	2.5
13.2	Нөлөөллийн бүсийн иргэд, сумын удирдлага, мэргэжилтэн	Төслийн үйл ажиллагааны талаар нөлөөллийн бүсийн иргэдэд жилд 2 удаа танилцуулсан байна.	2.5
			5
			100